



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 11 сарын 14 өдөр

Дугаар A/10

Улаанбаатар хот

Ажлын албаны бүтэц, орон тоо, албан
тушаалын жагсаалтыг шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 54 дүгээр зүйлийн 54.1, 54.2, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 375 дугаар тогтоолыг тус тус үндэслэн нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит II дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны орон тоог 8 байхаар тогтоож, төрийн захиргааны албан тушаалын жагсаалтыг нэгдүгээр, төрийн улс төрийн албан тушаалын жагсаалтыг хоёрдугаар, төрийн үйлчилгээний албан тушаалын жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, батлагдсан бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтын дагуу албан хаагчдыг томилон, Хурлын Ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (М.Давааням)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны А/09 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Төлөөлөгчдийн 2024 оны 11 дүгээр сарын 14-ний
өдрийн 1/10 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

Удирдах – 1

1. Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга– ТЗ-4

Зохион байгуулалтын хэлтэс- 7

1.Зохион байгуулалтын хэлтсийн дарга – ТЗ-6

2.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн- ТЗ-7

3.Хүний нөөц, өргөдөл гомдол, сургалт хариуцсан мэргэжилтэн– ТЗ-8

4.Эрх зүй, тогтоол шийдвэрийн биелэлт, орон нутгийн өмчийн асуудал хариуцсан
мэргэжилтэн - ТЗ-8

5.Хурлын зохион байгуулалт, шагнал, цагаатгалын асуудал хариуцсан
мэргэжилтэн - ТЗ-8

6.Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл, дотоод ажил, бусад чиг
үүрэг хариуцсан мэргэжилтэн - ТЗ-8

7.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, төсөл хөтөлбөр хариуцсан
мэргэжилтэн - ТЗ-8

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Төлөөлөгчдийн 2024 оны 11 дүгээр сарын 14 -ний
өдрийн 1/10 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



ТӨРИЙН УЛС ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

Төрийн улс төрийн албан тушаал - 4

- 1.Хурлын даргын зөвлөх - УТ
- 2.Хурлын даргын хэвлэл мэдээллийн ажилтан - УТ
- 3.Хурлын даргын туслах - УТ
- 4.Улс төрийн намын бүлгийн ажилтан – УТ

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Төлөөлөгчдийн 2024 оны 11 дүгээр сарын 11-ний
өдрийн 1110 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт



ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

Төрийн үйлчилгээний албан тушаал - 5

- 1.Ерөнхий нягтлан бодогч – ТҮМ-7
- 2.Архив, бичиг хэргийн эрхлэгч – ТҮМ-3
- 3.Мэдээлэл технологи, дотоод сүлжээ хариуцсан ажилтан – ТҮ-7
- 4.Механикч, жолооч – ТҮ-5
- 5.Нярав, эд хариуцагч – ТҮ-4